Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Гэрээ хэлэлцээр хариуцсан ахлах мэргэжилтэн, Саруул Пүрэвсүрэн

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3.1. Ногоон санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ногоон санхүүжилт татах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ногоон төсөл хөтөлбөрүүдийг бойжуулах, тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавина. | | | | | | | |
| 1 | 3.1.1. Ногоон эдийн засаг, ногоон санхүүжилтийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангах арга хэмжээг уялдуулан зохион байгуулна. | Боловсруулсан баримт бичиг, хүргүүлсэн саналын тоо /тоо/ | “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийг 2025 онд өргөн мэдүүлэхээр тусгасан. | Ногоон санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд холбогдох Ажлын хэсэгт орж ажиллаж, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулсан байна. /Уур амьсгалтын тухай анхдагч хуулийн төсөл-1 Холбогдох бусад эрх зүйн баримт бичигт өгсөн төслийн санал -3/ | 1. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай анхдагч хуулийн төсөл - Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий АХ-ийн хүрээнд хуулийн төсөл, дагалдах 10 гаруй хууль, Хууль тогтоомжийн тухай хууль /ХТтХ/-д заасан холбогдох судалгааг боловсруулсан. - Хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2025.04.18-нд хийж, 240 гаруй төлөөлөл оролцсон. - ЗГ-ын бүрэлдэхүүнд өөрчлөлт | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орсон тул АХ-ийг шинэчлэн байгуулахаар БОУАӨЯ-ны саналын 2025 оны 01/2138 бичгээр нэр хүргүүлсэн. - ЭЗХЯ-ны чиг үүрэгт хамаарах зохицуулалтыг сайжруулахаар донор байгууллагуудтай хамтран ажилласан. 2. Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төсөл - Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль /ЭЗЭЧтХ/-ийн төсөл, Хөрөнгө оруулалтын тухай хууль /ХОтХ/ болон Зөвшөөрлийн хууль, холбогдох 100 гаруй хуулийн төсөл, ХТтХ-д заасан холбогдох судалгааг боловсруулсан. - www.legalinfo.mn сайтад /2025.09.15-2025.11.15/ байршуулж санал авсан. Албан бичгээр 564, цахимаар 78 санал, нийт 642 санал ирснийг хуулийн төсөлд тусгасан. - МҮХАҮТ-тай хамтран 2025.10.02-нд хэлэлцүүлэг хийж, 250 гаруй төлөөлөл оролцсон. - ЗГ-ын 2025.11.12-ны хуралдаанд хуулийн талаар танилцуулж, ЗГ- | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ын 27-р тэмдэглэл гарсан. 12 сард багтаан ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлнэ. 3. Бусад хуулийн төсөл 1. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга - Гадаадын хөрөнгө оруулалтын тухай /ГХОтХ/ хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд мэргэжлийн холбоодын 180 саналд дүн шинжилгээ хийж, ХОтХ болон ГХОтХ-ийн харьцуулалт хийсэн. Яамны удирдлагууд, АХ-т үр дүнг танилцуулж, ХОтХ-д өөрчлөлт оруулахаар тогтсон. 2. Татварын багц хуулийн төсөл Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, Татварын ерөнхий хуулийг дагалдаж ХОтХ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжихгүй талаар татварын багц хуулийн төсөлд санал боловсруулж МЭЗБГ-т хүргүүлсэн. 3. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл ХБТТУтХ, хөгжлийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бодлогын баримт бичигт нийцүүлэх талаарх саналаа БОБГ-т хүргүүлсэн. Хавсралт: 3 файл | | |
| 2 | 3.1.2. Нэгдэн орсон олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах, хоёр талт болон олон талт гэрээнд нэгдэн орох асуудлыг судалж, санал боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавина. | Хүргүүлсэн саналын тоо /тоо/ | Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны хэлэлцээрийг БНСУ, Япон Улстай байгуулсан. | Парисын хэлэлцээрийн хүрээнд бусад улсуудтай хамтран хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр хоёр талт ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. /Хамтын ажиллагааны хэлэлцээр 1/ | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/680 дугаар тушаалаар байгуулсан "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр", "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Швейцарын Холбооны Зөвлөл хоорондын хэлэлцээр"-ийн Монголын талын хамтарсан ажлын хэсгийн хүрээнд 2 улстай хийх хэлэлцээрийн төсөлд санал өгч, яриа хэлэлцээнүүдэд орж, хэлэлцээрийн төслүүдийг эцэслэн боловсруулсан. 1. "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газар, Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр"-т гарын үсэг зурах эрх олгох тухай асуудлыг Засгийн газрын 2025.09.10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, гарын үсэг зурах эрхийг Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар нарт олгож, хэлэлцээрийг 2025.10.07-ны өдөр байгуулсан. 2. "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар болон Швейцарын Холбооны Зөвлөл хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурах эрх олгох тухай асуудлыг Засгийн газрын 2025.11.05-ны хуралдаанаар хэлэлцэж, гарын үсэг зурах эрхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатарт олгож, талууд 2025.11.20-ны өдөр хэлэлцээрийг байгуулсан. Дээрх хэлэлцээрүүдийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулснаар ногоон санхүүжилтээр гадаадын хөрөнгө оруулалт татах боломжтой болж, хямд эх үүсвэртэй гадаад валютын орох урсгал бий болно. Түүнчлэн олон улсын карбон зах зээлд оролцох нөхцөлийг бүрдүүлж, хамтран ажиллах боломжтой төсөл хэрэгжүүлэх ач холболдолтой юм. Түүнчлэн Сингапур, Швейцарын оруулалтаар сэргээгдэх эрчим хүч (ус, салхи, нарны), эрчим хүчний хэмнэлттэй технологи, хог хаягдлын менежмент, ойжуулалт, эрчимжсэн хөдөө аж ахуй, байгаль орчны нөхөн сэргээлт, тогтвортой дэд бүтэц зэрэг олон төрлийн карбон төслүүдийг хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Хавсралт: 5 файл | | |
| 3 | 3.1.3. Ногоон төслийг үнэлэх, эрэмбэлэх, тодорхойлох, ногоон төслийг нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлнэ. | Боловсруулсан баримт бичиг, хүргүүлсэн саналын тоо /тоо/ | - | НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын үнэлэх аргачлалд нийцүүлэн УХОХ, ЗГҮАХ, ҮТХН-3.0-т туссан ногоон төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх арга | 1. Ногоон төслийн үнэлгээ 1. Тогтвортой хөгжлийн зорилгын санхүүжилтийн таксономийн дагуу ногоон ангилалд орсон төслийг тодорхойлох, үнэлж, эрэмбэлсэн. а. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэмжээг хэрэгжүүлсэн байна. /Суурь судалгааны тайлан - 1, Ногоон төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал - 1, Ногоон төслийн жагсаалт - 1/ | ЗГҮАХ-т туссан 149, 2026-2030 оны УХОХ-т туссан 112, ҮТХН (NDC-3.0)-т туссан 21, нийт 282 төслийн мэдээллийн сан бүрдүүлсэн. б. Хөгжлийн төслүүдийг SDG Таксономи аргачлалын дагуу ангилахад эдийн засгийн 101, нийгмийн 73, ногоон 43 төсөл байна. 3. Ногоон ангилалд орсон 43 төслийг шүүлт хийж, босго үзүүлэлтийн шалгуур хангасан 32 төслийг тодорхойлсон. 2026-2030 оны УХОХ-т ногоон ангиллын босго үзүүлэлтэд хүрсэн 32 төслөөс 28 төсөл туссан байна. Үүнээс эрчим хүчний 10, ногоон хөгжлийн 8, бүсчилсэн хөгжлийн 8, эдийн засгийн бүтцийн шинэчлэлийн 1, засаглалын 1 төсөл байна. 2. Тэргүүлэх ач холбогдол бүхий ногоон төслийн бэлэн байдлыг хангуулах Сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрүүд болон цахилгаан тээврийн хэрэгслийн дэд бүтцийн багц төслийг хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан | сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжүүлэхээр төслийн бэлэн байдлыг хангуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Төслийг хөгжлийн бодлого, арга хэмжээтэй нийцсэн байдал, нийгэм, эдийн засгийн үзүүлэх нөлөөллийг судалсан. 1. Цахилгаан автомашины цэнэглэх станцын дэд бүтцийн байгууламжийг Монгол Улсын аялал жуулчлал төв зам, гадаад худалдаа, логистикийн зам, уул уурхайн экспортын зам дагуу 43 байршилд байгуулах; 2. Сэргээгдэх эрчим хүчний нийт 178 МВт хүчин чадалтай эх үүсвэр, эрчим хүчний тогтвортой байдлыг хангах 93 МВт.цаг багтаамж бүхий зай хураагуурыг 43 байршилд бий болно. 3. Ногоон барилгын LEED сертификат үйлчилгээ, амралтын байгууламж бүхий зогсоолын дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлнэ. Төсөл нь аялал жуулчлалын гол зам дагуу EV цэнэглэх станцуудыг байгуулж, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аялагчдад тав тухтай нөхцөл бүрдүүлэхээс гадна орон нутгийн иргэдийг ажлын байраар хангаж, орон нутгийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Төслийн саналыг хөгжлийн санхүүжүүлэгч байгууллагуудад танилцуулж, хамтын ажиллах санал хүргүүлсэн. Хавсралт: 3 файл | | |
| 4 | 3.1.4. Ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, ногоон төсөл, хөтөлбөрүүдийг нэмэгдүүлэх, ногоон санхүүжилтийн эх үүсвэр татах чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлнэ. | Хэрэгжиж эхэлсэн төслийн тоо /тоо/ | - | Хамтын ажиллагааны хүрээнд ногоон эдийн засаг, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. /Хэрэгжиж эхэлсэн төсөл - 2/ | 1. "Монгол Улсад нүүрстөрөгчийн зах зээлийн бэлэн байдлыг бэхжүүлэх нь" төслийг шинээр хэрэгжүүлж эхэлсэн. Санхүүжүүлэгч: Уул амьсгалын ногоон сан Хугацаа: 2025-2026 Хамтран хэрэгжүүлэгч: БОУАӨЯ, СЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр - Парисын хэлэлцээрийн 6-р зүйлийн хүрээнд Монгол Улсын нүүрстөрөгчийн зах зээлийг бий болгох, эрх зүйн, техникийн болон үйл ажиллагааны суурийг бий болгох зорилготой. - Төслийн 2025 оны төслийн төлөвлөгөөнд санал хүргүүлж, төлөвлөгөөг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

245

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | УХ-ны хурлаар баталгаажуулсан. - Төслийн хүрээнд 4 гэрээт зөвлөхийг НСБХ-т ажиллуулахаар шийдвэрлүүлж, 2026 онд 3-6 сарын хугацаанд ажиллуулахаар сонгон шалгаруулсан. 2. Азийн тогтвортой дэд бүтцийн хөтөлбөр (Sustainable infrastructure programme in Asia, SIPA) төслийн хэрэгжилтийг эрчимжүүлсэн. Санхүүжүүлэгч: Германы ЗГ, ЭЗХАХБ Хугацаа: 2024-2026 Хамтран хэрэгжүүлэгч: НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр - Төв болон Зүүн Өмнөд Азийн улс орнуудын дэд бүтцийн хөрөнгө оруулалтын шийдвэрийг Парисын хэлэлцээр, ТХЗ-той уялдуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой. - Төслийн хүрээнд эрчим хүч, зам тээврийн салбарын нөхцөл байдлын шинжилгээг төслийн 2 зөвлөхтэй хамтран гүйцэтгэсэн. - Тогтвортой дэд бүтцийн хөгжил болон ногоон санхүүжилтийн ач холбогдол, олон улсын сайн туршлага, | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дотоодын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд болон ногоон санхүүжилтийн талаар хэлэлцүүлгийг 2025.11.17-нд зохион байгуулсан. 3. Бусад хамтын ажиллагаа 1. GIZ хэрэгжүүлж "Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих (ICED)" төслийн 2 дахь шатны төсөлд ногоон санхүүжилтийн чиглэлээр санал хүргүүлсэн. 2. НҮБ-ын ХХААБ, БОУАӨЯ-ны Уур амьсгалын өөрчлөлтийн ил тод байдлыг сайжруулах нь (CBIT–2) төлөвлөгөөнд санал өгсөн. 3. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ДБ, АХБ-д хууль, ногоон төслийн талаар хамтран ажиллах санал хүргүүлсэн<br>Хавсралт: 5 файл | | |
| 5 | 3.1.5. Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр болон цаг үеийн асуудлаар удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын | Тушаал, шийдвэр, Ажлын хэсгийн тоо /тоо/ | - | Засгийн газар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байна. /Ажлын хэсгийн тоо - 3-аас доошгүй/ | 1. Ажлын хэсэг Яамны удирдлагуудын орсон дараах Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж, ЗГ-ын хуралдаан, АХ-ийн хурлын бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай мэдээ, тайлан, танилцуулга | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангана | | | | боловсруулж ажилласан. 1. Уул уурхайн экспортыг дэмжих дэд ажлын хэсэг - ЕС-ын 2025 оны 41 дүгээр захирамжаар байгуулсан экспортыг нэмэгдүүлэх, худалдааг дэмжих Ажлын хэсэг - Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/09 дүгээр тушаалаар байгуулсан Ажлын дэд хэсэг 2. Ерөнхий сайдын 2025 оны 67, 68, 73 дугаар захирамжаар байгуулсан Оюутолгой төсөл, "Онтре" компанийн хувьцааны төрийн эзэмших хувь, хэмжээг тогтоох Ажлын хэсгүүд, АҮЭБС-ын 2025 оны А/212 дугаар тушаалаар байгуулсан Эдийн засаг, санхүү, татварын асуудал хариуцсан Дэд ажлын хэсэг 3. ЕС-ын 2025 оны 60 дугаар захирамжаар байгуулсан "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулах төслийн ажлын хэсэг 4. ЕС-ын | сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025 оны 62 дугаар захирамжаар байгуулсан “Петрочайна дачин тамсаг” ХХК Болон “Доншен газрын тос /Монгол/” ХХК-тай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой Ажлын хэсэг, АҮЭБС-ын 2025 оны А/208 дугаар тушаалаар байгуулсан Дэд ажлын хэсэг 5. Ерөнхий сайдын 2025 оны 59 дүгээр захирамжаар байгуулсан . Багануурын уурхайг түшиглэн “Нүүрс-хими, кокс-химийн цогцолбор”-ын төслийн ажлын хэсэг 2. Бусад үүрэг даалгаврын биелэлт - Хөрөнгө оруулагчийн гомдол шийдвэрлэх хүрээнд ЗГХХГ-тай хамтран ажилласан. - Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу илтгэл, танилцуулга боловсруулсан. - Төлөвлөгөө, тайлангийн биелэлт, дотоод арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлсэн. Жич: Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар оруулав.<br>Хавсралт: 1 файл | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх | - | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байна. /100%/ | 1. Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) 2025 оны дээд хэмжээний уулзалтыг угтсан "Жижиг, дунд үйлдвэрийн сайд нарын түвшний уулзалт"-ын хүрээнд зохион байгуулагдаж буй "Жижиг, дунд үйлдвэрийн цахим шилжилт" форум болон Дэлхийн банк, Солонгосын Жижиг, дунд үйлдвэр, гарааны бизнесийн агентлаг (KOSME)-аас хамтран зохион байгуулсан "Жижиг, дунд үйлдвэр, гарааний бизнесийн бодлого" семинарт оролцсон. "Жижиг, дунд үйлдвэрийн цахим шилжилт" форум, "Жижиг, дунд үйлдвэрийн бодлого" семинар нь Бүгд Найрамдах Солонгос Улсын Чэжү мужид 2025 оны 09 дүгээр сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. 2. БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос зохион байгуулсан | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Хятад-ШХАБ-ын Ногоон үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа" сэдэвт семинар болон "Ногоон аж үйлдвэрлэлийн шинэ платформыг хамтдаа бүтээж, бүс нутгийн хамтын ирээдүйг цогцлоох нь" сэдэвт форумд оролцсон. Семинар, форумын арга хэмжээ БНХАУ-ын Бээжин, Тяньжин хотноо 2025 он 10 дугаар сарын 11-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. | | |
| 2 | Яамнаас зохион байгуулсан мэдээллийг цагт оролцсон байна. | Яамнаас зохион байгуулсан мэдээллийг цагт оролцсон байх | - | Яамнаас зохион байгуулсан мэдээллийг цагт оролцсон байна. /100%/ | - Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цаг, арга хэмжээнд тогтмол хамрагдсан. - Яамны албан хаагчдад зориулсан 1 хэлэлцүүлгийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан.<br>Хавсралт: 3 файл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ХЯНАСАН:

......Б. Анар-г....../......Б. Тогосүрэн....../ Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гэрээ хэлэлцээр хариуцсан ахлах мэргэжилтэн, Саруул Пүрэвсүрэн /........................................./ Огноо: 2025.12.15

ТУ32861 6806236 9022010236

25